

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1.	Аудитын гэрчилгээ.....	2
2.	Аудитын тайлан .....	4
2.1	Оршил .....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал .....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	11
3.	Менежментийн захидал.....	12
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	14
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
НОМЫН САНГИЙН ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ИЧИНХОРЛОО ТАНАА

2019.02.25 № 06/298  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсын үндэсний номын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Улсын үндэсний номын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол улсын үндэсний номын сангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТЫН ТАЙЛАН

### 2.1 ОРШИЛ

Монгол Улсын үндэсний номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Улсын үндэсний номын сангийн захирлын үүрэг гүйцэтгэгч Б.Ичинхорлоо Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монголын үндэсний номын сангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын үндэсний номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 1 дүгээр сарын 02-ноос 2019 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Эс Жи Эм Ди Аудит ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын үндэсний номын сан 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 26 дугаар тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монголын үндэсний номын сангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Монгол Улсын үндэсний номын сан нь “Соёлын өв, оюуны бүтээлийг цуглуулан баяжуулж, хадгалан хамгаалж, нээлттэй хүртээмжтэй мэдээллээр үйлчлэх, түгээх хойч үед өвлүүлэн үлдээх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Монгол Улсын Номын сангийн тухай хууль, Монгол Улсын үндэсний номын сангийн дүрэмд тус номын сангийн зорилгыг “...гар бичмэл, барын ном, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл, Монгол Улсад хэвлэгдсэн ном, сонин сэтгүүл болон хэвлэлийн бусад бүтээгдэхүүн, чухал хэрэгцээтэй гадаадын ном зохиол, тогтмол хэвлэлийг бүрдүүлэн хадгалах, бүртгэл мэдээллийн сан бий болгох, уншигчдад шуурхай үйлчлэх, бусад номын сангуудыг мэргэжил арга зүйн удирдлага, мэдээллээр хангах” гэж тодорхойлсон.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын шийдвэрээр Монгол Улсын үндэсний номын сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эртний болон орчин үеийн ном, хэвлэлийн бүтээгдэхүүнээр номын сангийн сан хөмрөгийг баяжуулах, иргэдэд үйлчлэх
- Эрдэм шинжилгээ, судалгаа

Монгол Улсын үндэсний номын сангийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол Улсын үндэсний номын сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Номын сангийн тухай хууль
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт ороогүй болно.

Монгол Улсын үндэсний номын сан нь тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

#### 1. Үндэсний бичиг үсэг, соёлын баримтат өвийг сурталчлах ажил:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, бичиг соёлын дурсгалаа сурталчлах зорилгоор жил бүр зохион байгуулдаг “Үндэсний бичиг үсгийн баяр-2018” арга хэмжээ 2018 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 6-ны өдрүүдэд улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлсэн.

Үндэсний бичиг үсгийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн А/217 тоот тушаал гарч, улс орон даяар “Үндэсний бичиг үсэг - Тусгаар тогтнол” уриан дор нэгдсэн хөтөлбөр, зохион байгуулалт, удирдамжийн дагуу аймаг, нийслэл, орон нутагт 76 ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн.

“Үндэсний бичиг үсгийн баяр-2018” арга хэмжээний мэдээллийн ивээн тэтгэгчээр Монголын үндэсний олон нийтийн радио телевиз, TV5 телевиз болон бусад хэвлэл мэдээллийн байгууллагууд ажиллаж, 5 дугаар сарын 4-ний нээлтийн ёслол болон бусад үйл ажиллагааг нэвтрүүлсэн ба бичиг үсгийг олон нийтэд сурталчлах, үйл ажиллагааг танилцуулах шторк зарыг 3 төрөл, хэлэлцүүлэг нэвтрүүлэг 2 удаа бэлтгэн үзэгч олонд хүргэсэн.

“Судар бичгийн алтан сан” нэвтрүүлгийг Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран бэлтгэж, 20 удаагийн цуврал нэвтрүүлэгт эрдэмтэн, судлаачдыг оролцуулан, олон нийтэд сурталчилсан.

Үндэсний баримтат өвийн нэгдсэн мэдээллийн сангийн [www.nationalheritage.mn](http://www.nationalheritage.mn) бүртгэлийн программыг шинээр хийж Соёлын өвийн төв, ЮНЕСКО-ийн үндэсний комиссын Веб сайттай холбосон. Үнэт ховор номын музейг сурталчлах зорилгоор атрибут нэмж хийсэн.

2 “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн Монголын үндэсний комиссын ажил:

2017 онд ЮНЕСКО-ийн “Дэлхийн дурсамж” хөтөлбөрийн олон улсын дэлхийн өвийн жагсаалтад бүртгэсэн “Данжуурын гэрэлт хөшөө” өвийн батламжийг 2018 оны 3 дугаар сард хүлээн авч, нийт 7 өвийг дэлхийн болон бүс нутгийн өвд бүртгүүлсэн.

Төвд номын сан хөмрөгийн ном судрыг дижиталчлах АСIP төсөл: Монгол Улсын үндэсний номын сангийн төвд номын сангийн сан хөмрөг нь нэг сая гаруй ном судартай бөгөөд электрон каталог бүртгэлд оруулах, эх хувийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор төсөл хэрэгжүүлж ирсэн ба Төвд номын сан хөмрөгийн ном судрыг дижиталчлах АСIP төсөлтэй хамтын ажиллагааны гэрээг боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны гадаад харилцааны хэлтэс, Гадаад хэргийн яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын зөвшөөрлийг үндэслэн 10 дугаар сарын 24-ний өдөр албан ёсоор 2 тал гэрээ байгуулж гарын үсэг зурсан ба төслийн үйл ажиллагаа үргэлжилж байна. Төслийн хүрээнд АСIP-ийн каталогчид нийт 4,349 гарчиг номыг каталогт бүртгэн оруулаад байна. Түүнээс дижиталчлах каталогч нар 1,463 боть судар бүртгэн, 53,689 хуудас цахим хэлбэрт орсон бөгөөд 125 багц судар боловсруулалтад орж бүрэн дууссан бөгөөд BDRС веб сайтад байршуулсан.

Өрнө дахины сан хөмрөг дэх 616,167 номын бүрэн тооллогын комисс тайлангийн хугацаанд 207,727 нэрийн, 256,555 ширхэг ном тоолж, нэг бүрчилсэн бүртгэлтэй тулгаж, үнийг шивж оруулан 1,3,4 дугаар форматын 179,756 ширхэг номыг тулгаж "Тоолов" тэмдэглэгээг хийгээд байна. Тооллогоор номын мэдээллийн сан үүсгэн, номын нэг бүрчилсэн бүртгэлийн жагсаалт, шилжүүлсэн, хасагдсан болон дутагдсан номын бүртгэлүүдийг шүүн гаргах, эрэмбэлэх ажлуудыг хийн, номын дансны үнийг тулган оруулж байгаа нь олон талын ач холбогдолтой электрон каталогт орох, бүртгэл, данс цэгцлэх, номын дахин үнэлгээ хийх ажилд үр дүнтэй ажил болсон.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай ХОЛБООТой ХУЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.



Монгол Улсын үндэсний номын сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Улсын үндэсний номын сан санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous 3.0" програм хангамж ашигладаг байна.

Монгол Улсын үндэсний номын сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Монгол Улсын үндэсний номын сангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 2.0 хувиар сонгов.

Материаллаг байдлын суурийг нийт хөрөнгөөр сонгоход их байгаа тул нийт зардлаар сонгов.

Монголын Улсын үндэсний номын сангийн 2018 оны нийт зардал 1,421,517.0 мянган төгрөг бөгөөд түүний 2.0 хувь болох 28,430.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2.0 хувиар тооцсон нь санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	27,798.6	
2	Албан шаардлага өгсөн	3	799.6	
<b>Дүн</b>		<b>5</b>	<b>28,598.2</b>	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- “Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6 дахь хэсэг “Төрийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа /бусад орлого/-наас орох орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэснийг мөрдөж ажиллаагүйн улмаас тайлант хугацааны эцэст 153.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ асуудалд “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын дагуу албан шаардлага хүргүүлээ.
- Эздийн өмч буюу засгийн газрын хувь оролцооны дүн нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд 1,290,110.6 мянган төгрөгөөр, санхүүгийн тайланд 1,834,267.0 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэсэн байна. Зөрүү 544,156.4 мянган төгрөг байна. Энэ асуудалд “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын дагуу албан шаардлага хүргүүлээ.
- Урьд оны авлагаас он дамжсан 646.3 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна. Энэ нь холбогдох этгээд нь ажлаас гарсан, өөр оронд ажиллаж амьдарч байгаатай

холбоотой юм байна. Энэ асуудалд “Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам”-ын дагуу албан шаардлага хүргүүлээ.

## **2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Өрнө дахины сан хөмрөг дэх 616,167 номын бүрэн тооллогын комиссын тайлан, Түвд, эртний ховор номын бүртгэлийн явцыг авч үзэх

### **2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол Улсын үндэсний номын сангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,190,201.6 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,178,797.3 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардлын хэмнэлтээс шалтгаалжээ.

### **2.11 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Монгол Улсын үндэсний номын сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим системийн дагуу 5.0 сая төгрөгөөс дээш ажил гүйлгээний 145 удаагийн 2,917,526.5 мянган төгрөгийн мэдээллийг хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 90 хувьтай байна.

Урьд оны авлагаас он дамжсан 646.3 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна. Энэ нь холбогдох этгээд нь ажлаас гарсан, өөр оронд ажиллаж амьдарч байгаатай холбоотой юм байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ**

Бид Монгол Улсын үндэсний номын сангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Улсын үндэсний номын сангийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монголын үндэсний номын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаагаатай холбоотой асуудал**

##### **1.1 Илрүүлэлт:**

Хандиваар хүлээн авсан номын баринтгийг үнэлж орлогод авах, зардлыг тухайн барааны өртөгт оруулан тооцож, анхан шатны баримттай тулган бүртгэлд аваагүй байна. Энэ нь тайлагнал тодруулга батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5 дахь заалт болон УСНББОУС12-ыг тус тус зөрчсөн байна.

##### **1.2 Эрсдэл:**

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх,
- Хэрэглэгчдэд мэдээлэл зөрүүтэй хүрэх,

##### **1.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5 дахь заалт болон УСНББОУС12-ын дагуу импортоор авсан материалын зардлыг тухайн барааны өртөгт оруулан тооцож байх, мөн хандивын орлогыг бүртгэж холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэн мөрдөж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

##### **1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Хандиваар ирж буй баринтаг нь анхан шатны баримтгүй, үнэ тодорхойлох боломжгүй учир бүртгэлд аваагүй. Цаашид хандиваар ирсэн номын баринтагийг үнэлэх

журмыг боловсруулан баталж, УСНББОУС12-ыг мөрдөн ажиллаж хандиваар авсан номын баринтгийг 2019 оны эхний улиралд багтаан нөхөн бүртгэнэ.

## **2. Балансын данстай холбоотой асуудал**

### **2.1 Илрүүлэлт:**

Бэлэг болон солилцоогоор хүлээн авсан номнуудын нэршлийг тодорхой болгон бүртгэлд тусгаагүй, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг ангилал тус бүрээр тулган зөв ангилан бүртгээгүй.

Энэ нь иж бүрэн байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5 дахь заалт, УСНББОУС-17 тус тус зөрчсөн байна.

### **2.2 Эрсдэл:**

- Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх
- Хэрэглэгчдэд мэдээлэл зөрүүтэй хүрэх

### **2.3 Өгсөн зөвлөмж**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5 дахь заалт болон УСНББОУС17-гийн дагуу бэлэг болон солилцоогоор хүлээн авсан номнуудын нэршлийг тодорхой болгон бүртгэлд тусган ажиллах зөвлөмж хүргүүлээ.

### **2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

2018 онд бэлгийн 925 нэр төрлийн 2,142 ширхэг 27,798.6 мянган төгрөгийн солилцоогоор 295 нэрийн 304 ширхэг 3,471.0 мянган төгрөг нийт 31,269.6 мянган төгрөгийн үнэ бүхий ном бүрдүүлсэн. Нийт бүрдүүлсэн номыг 7 фондод хуваарилан тоо ширхэг нэг бүрийн үнээр санхүүгийн програмд үндсэн хөрөнгөөр бүртгэсэн. Номын бүртгэлийн дэлгэрэнгүйг номын сангийн “Коха” програмаар бүртгэдэг. Санхүүгийн програмд бүртгэхэд олон хэлээр бүртгэх шаардлагатай байдаг тул /хятад, солонгос, түвд, манж, гэх мэт/ нэр бүрээр бүртгэх боломжгүй учир Коха програмыг санхүүгийн програмтай уялдуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

##### 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>95 776 362,98</u></b>	<b><u>158 124 722,02</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	584 560,00	153 260,00
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	584 560,00	153 260,00
31110	Төгрөг	584 560,00	153 260,00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6 066 615,98	27 477 962,02
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	665 350,00	744 600,94
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	5 401 265,98	26 733 361,08
3351	Байгууллагаас авах авлага	3 558 557,58	26 086 927,68
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1 842 708,40	646 433,40
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	12 086 506,00	8 341 700,00
34600	Урьдчилж гарсан зардал	9 833 750,00	8 341 700,00
<b>3471</b>	<b>Урьдчилгаа тооцоо</b>	2 252 756,00	00,00
34714	Томилолтын урьдчилгаа	2 252 756,00	00,00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	77 038 681,00	122 151 800,00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2 500 000,00	00,00
35110	Тусгай зориулалттай материал	2 500 000,00	00,00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	903 745,00	48 327 015,00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	73 634 936,00	73 824 785,00
35410	Бичиг хэргийн материал	34 570 342,00	31 541 322,00
35420	Аж ахуйн материал	4 235 664,00	5 532 011,00
35430	Сэлбэг хэрэгсэл	00,00	9 994 000,00
35440	Түлш, шатах тослох материал	18 000,00	6 500,00
35450	Барилгын засварын материал	2 604 890,00	3 674 140,00
35470	Бусад хангамжийн материал	32 206 040,00	23 076 812,00
